



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 09 сарын 20 өдөр

Дугаар А/241

Номгон

Г

Г

Агаарын хөлөг шувуу, мал, амьтантай
мөргөлдөх аюулаас сэргийлэх Баянхонгор
аймаг дахь салбар зөвлөл шинэчлэн
байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, "Аэродром орчимд агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх" MNS 6942:2021 стандартын 5.7.2 дахь заалт, "Агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх журам"-ын 2.13, 2.14, 3.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүн"-ийг нэгдүгээр хавсралтаар, зөвлөлийн үйл ажиллагааны журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2.Салбар зөвлөлийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулж, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн уялдаа холбоо, оролцоог хангуулан ажиллахыг Салбар зөвлөлийн дарга, аймгийн Засаг даргын орлогч (Б.Наранбаяр), салбар зөвлөлийн үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг тухай бүр шийдвэрлэж, дэмжлэг үзүүлэн ажиллахыг "ИНУТ" ТӨХХК ийн харьяа Баянхонгор нисэх буудал (Д.Мөнхжаргал)-д тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Энхбаяр)-т, Баянхонгор нисэх буудал (Д.Мөнхжаргал)-д тус тус даалгасугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан "Агаарын хөлгийг шувуу, мал амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх" Баянхонгор аймаг дахь салбар зөвлөл байгуулах тухай 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/277 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  ЭНХБАТ

626010641

Аймгийн Засаг даргын 2016 оны 04 дүгээр
сарын 20-ны өдрийн 4/34.1 дүгээр
захирамжийн дүгээр хавсралт

АГААРЫН ХӨЛӨГ ШУВУУ, МАЛ, АМЬТАНТАЙ МӨРГӨЛДӨХ
АЮУЛААС СЭРГИЙЛЭХ БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:

- Аймгийн Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга:

- Баянхонгор нисэх буудлын дарга

Гишүүд:

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө, оруулалт
бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

- Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын дарга

- “Цэвэр хот” ОНӨААТҮГ дарга

- Байгаль орчны газрын дарга

- Баянхонгор сумын Засаг дарга

- “Чандмань Баянхонгор” ХК-ийн дарга

- Зооноз өвчин судлалын төвийн дарга

- Өлзийт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга

- Нисэх буудлын нислэгийн удирдагч

- Нисэх буудлын аэродромын инженер

- Нислэг үйлдэж буй авиа кампани төлөөлөгч

_____оОо_____

Аймгийн Засаг даргын оны дүгээр
сарын ны өдрийн дүгээр
захирамжийн дугаар хавсралт

**АГААРЫН ХӨЛӨГ ШУВУУ, МАЛ, АМЬТАНТАЙ МӨРГӨЛДӨХ
АЮУЛААС СЭРГИЙЛЭХ БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ**

Нэг: Ерөнхий зүйл

1.1 Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцын Хавсралт 14 "Бүлэг-1 Аэродромын төлөвлөлт болон үйл ажиллагааны 9.4.3-т "Агаарын хөлөгтэй шувуу ба амьтад мөргөлдөх магадлалыг хамгийн бага түвшинд байлгахад тохирсон арга хэмжээг авч агаарын тээвэрлэгчид учрах эрсдэлийг бууруулна" гэж, мөн Док9137 "Нисэх буудлын ерөнхий зааврын Бүлэг 2 "Хүрээлэн буй орчны менежментийн хөтөлбөр 2.15-д "Зөвлөл байгуулж ажиллах, хуралдаан зохион байгуулах" гэж тус тус заасныг үндэслэн Агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх салбар зөвлөл (цаашид "салбар зөвлөл" гэх)-ийг байгуулж, зөвлөлийн үйл ажиллагааны журмыг боловсруулсан болно.

1.2 Салбар зөвлөл нь нисэх буудлын аэродром, түүний хяналтын цэгээс 13 километр радиус дотор, ялангуяа ойртолтын бүсэд агаарын хөлөг шувуутай мөргөлдөх аюулаас сэргийлэх, эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, нисэх буудлууд, агаарын тээвэрлэгчдийн уялдаа холбоо, үйл ажиллагааг зохицуулах, мэргэжлийн зөвлөмж өгөх үүрэг бүхий орон тооны бус нэгж юм.

1.3 Тус салбар зөвлөлийн үйл ажиллагаа нь Иргэний нисэхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 "Олон улсын гэрээ хэлэлцээрийн хүрээнд нисэхийн аюулгүй ажиллагааг хангуулах арга хэмжээ авах бүрэн эрхтэй" гэж тус тус заасны дагуу агаарын хөлгийг шувуу, мал, амьтантай мөргөлдөх эрсдэлийг бууруулахад оршино.

Хоёр: Салбар зөвлөлийн зохион байгуулалт

2.1. Салбар зөвлөлийн ажиллах үндсэн хэлбэр нь хурал байх ба хурлаас гаргасан шийдвэр нь зөвлөмж эсвэл үүрэг даалгавар хэлбэртэй байна.

2.2. Салбар зөвлөлийн хурлыг жилд 2-оос доошгүй удаа хуралдуулах ба шаардлагатай тохиолдолд тухай бүрд хуралдуулна.

2.3. Салбар зөвлөлийн ээлжит бус хурлыг зөвлөлийн даргын шийдвэрээр зарлан хуралдуулна.

2.4. Салбар зөвлөлийн гишүүдийн гуравны хоёроос багагүй нь оролцсон

тохиолдолд хурлыг хүчинтэйд тооцно.

2.5. Салбар зөвлөлийн хурлыг зөвлөлийн дарга даргалж, хурлын дэгийг мөрдүүлнэ.

2.6. Салбар зөвлөлийн хурлын материалыг ажлын гурваас доошгүй өдрийн өмнө гишүүдэд тараасан байна.

2.7. Хурлаар хэлэлцэх зарим асуудлаар салбарын ажилтан, мэргэжилтнээс бүрдсэн ажлын хэсэг байгуулж санал, дүгнэлтийг нь сонсож болно.

2.8. Салбар зөвлөлийн хурлын шийдвэр нь олонхын саналд үндэслэнэ. Санал тэнцсэн тохиолдолд хурал даргалагчийн саналаар шийдвэр гаргана.

2.9. Салбар зөвлөл нь аливаа асуудлыг судлах, хэрэгжүүлэхтэй холбоотойгоор судалгааны болон техникийн ажлын хэсгүүд байгуулан ажиллуулж болох ба ажлын хэсгийг тухай бүр зөвлөлийн дарга томилно.

2.10. Шаардлагатай тохиолдолд ажлын хэсэг нь үйл ажиллагаандаа өөрсдийн удирдлагад буй холбогдох мэргэжилтнүүд, тодорхой мэргэжлийн экспертүүдийг татан оролцуулж болно.

Гурав. Агаарын хөлгийг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх талаар Баянхонгор болон бусад гишүүн байгууллагуудын хүлээх үүрэг.

3.1 Баянхонгор нисэх буудал (цаашид "Баянхонгор нисэх" гэх) нь дараах үүргийг хүлээнэ:

3.1.1 Агаарын хөлгийг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас урьдчилан сэргийлэх, бууруулах, хэрэгжилтэд хяналт тавих, зохицуулалтыг хариуцах;

3.1.2 Шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас урьдчилан сэргийлэх бодлого, стандарт, журмын зохицуулалтад хяналт тавих, хэрэгжилтийг хангаж ажиллах, аэродромын бүх оролцогч талууд, бусад агентлагууд, төрийн байгууллагуудын оролцоог сайжруулахад дэмжлэг үзүүлэх;

3.1.3 Шувуу, мал, амьтантай холбоотой зөрчлийн мэдээллийг нэгтгэх, дүн шинжилгээ хийх, дүгнэлт гаргаж, оролцогч байгууллагуудыг мэдээллээр хангах, зөвлөмж өгөх.

3.1.4 Аэродромыг гэрчилгээжүүлэхэд тухайн нисэх буудлын Аэродромын ерөнхий зааварт шувуу, мал, амьтны аюулаас сэргийлэх зохицуулалтыг холбогдох шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг баталгаажуулах.

3.2 Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (цаашид "Байгаль орчин, аялал жуулчлалын газрын" гэх) нь дараах үүрэг хүлээнэ:

3.2.1 Иргэний нисэхийн ерөнхий газар болон аэродромын үйл ажиллагаа

эрхлэгчийг шувуу, мал, амьтдын зүйл, популяцийн хандлага, амьдрах орчин сонголт, бөөгнөрлийн бүсүүд, биологийн зан төрх, хүн ба амьд байгалийн зөрчилдөөний талаарх мэргэжлийн арга зүйгээр хангах.

3.3 Барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (цаашид “Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын гэх) нь дараах үүрэгтэй:

3.3.1 Нисэх буудлын аэродромын аюулгүйн бүсийг “Аэродромын төлөвлөлт ба ашиглалт” техникийн баримт бичгийн дагуу Баянхонгор нисэх буудал, “Тухайн аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагатай хамтран тогтоосны дараа газрын мэдээллийн санд оруулах;

3.3.2 Аэродромын аюулгүйн бүсэд газар, барилга байгууламжийн төлөвлөлт хийх тохиолдолд “Аэродромын төлөвлөлт ба ашиглалт” техникийн баримт бичигт заасны дагуу Баянхонгор нисэх буудалтай зөвшилцөж шийдвэрлэх;

3.3.3 Газар ашиглалтын талаарх мэдээллээр Баянхонгор нисэх буудлыг хангах.

3.4 Агаарын тээвэрлэгч (цаашид “Нислэг үйлдэж буй авиа кампани төлөөлөгч” гэх) нь дараах үүрэг хүлээнэ:

3.4.1. Шувуу, мал, амьтантай холбоотой зөрчлийн бүх тохиолдол болон аюулын талаар аэродромын үйл ажиллагаа эрхлэгчдэд үнэн, бодитой, шуурхай мэдээлэх;

3.5. Чандмань Баянхонгор (цаашид “Чандмань Баянхонгор ХК” гэх) нь дараах үүрэг хүлээнэ:

3.5.1. Шувуу мал амьтантай холбоотой зөрчил цэвэрлэх байгууламж дээр болон орчим шувуу цугларах нөхцөлийг нисэх буудалтай хамтарч бууруулах арилгах.

3.6 Аймгийн засаг даргын Тамгын газрын (цаашид “Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс” гэх) нь дараах үүрэг хүлээнэ.

3.6.1. Тухайн суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад “Аэродромын төлөвлөлт ба ашиглалт” техникийн баримт бичигт заасны дагуу аэродромын гэрчилгээ эзэмшигч, үйл ажиллагаа эрхлэгчдэд мэдэгдэх, хамтран ажиллах, зөвшилцөж шийдвэрлэх:

3.7. Цэвэр хот (цаашид Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар” гэх) нь дараах үүрэг хүлээнэ.

3.7.1. Тухайн аэродромын орчим хаягдсан сэг зэм гарсан илэрсэн үед мэдэгдэж холдуулах ажлыг хамтран зохион байгуулах.

3.8 Зооноз өвчин судлалын (цаашид “Зооноз өвчин судлалын төв” гэх) нь дараах үүрэг хүлээнэ.

3.8.1. Аюулгүйн бүс аэродром орчмын тандалт судалгаа хийж, шувуунаас хүнд халдварлах аюултай өвчний эрсдэлийг эрт илрүүлэх урьдчилан сэргийлэх.

3.8.2. Тухайн аэродромын орчимд өвчтэй үхлийн шалтгаан тодорхойгүй зэрлэг мал, амьтан, шувуу илэрсэн үед мэдэгдэх.

3.9 Баянхонгор сум (цаашид Баянхонгор сумын засаг дарга" гэх) нь дараах үүрэг хүлээнэ.

3.9.1. Аэродромын гэрчилгээ эзэмшигчээс хүргүүлсэн шувууны бөөгнөрөл, мал амьтны аюулын эрсдэл үүсгэж буй талаарх мэдээллийн дагуу холбогдох иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад аюулын талаарх мэдээлэл өгөх, шаардлага хүргүүлж зөрчлийг арилгах хариу арга хэмжээг авах, шаардлагатай тохиолдолд салбар зөвлөлд улимжилж шийдвэрлүүлэх.

3.10. Өлзийт сумын (цаашид "Өлзийт сумын ИТХ-ын дарга" гэх) нь дараах үүрэг хүлээнэ.

3.10.1. Өлзийт сумын нутаг дэвсгэрт хамрагдах Хөөрч буух хучилтай зурвасын 34 талд байрлах карьер дотор хаягдсан барилгын хог хаягдлын хамт дарах ажлыг хурлын шийдвэрээр хөрөнгийг шийдвэрлэж дарж тэгшлэх.

3.10.2. Аэродромын хяналтын цэгээс 3-8 км байрлах сумын айл өрхүүдэд шувуу цугларах нөхцөл бүрдүүлэхгүй хог хаягдал ил задгай хаяхгүй байх санамжууд өгөх.

Дөрөв. Үйл ажиллагааны хяналт

4.1. Салбар зөвлөлийн гишүүн байгууллага агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх зөвлөлийн тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд санал тусган зөвлөлд хүргүүлнэ.

4.2 Салбар зөвлөлийн гишүүн байгууллага нь чиг үүргийн дагуу шувуу, мал, амьтны аюулаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллана.

4.3. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг Зөвлөлийн нарийн бичгийн даргын ажлын алба нэгтгэн тайлагнаж. Жилд 2 удаа Нисэх буудлуудын үйлчилгээний газрын Аэродромын үйл ажиллагаа хариуцсан технологич мэргэжилтэнд хүргүүлнэ.

Тав. Шувуу мал амьтнаас сэргийлэх санхүүжилт

5.1. Агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх үүрэг хүлээсэн байгууллагууд нь хариуцсан үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүр байгууллагын төсөвт тусган хэрэгжүүлнэ.